

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БҮЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: ХЭА-2020/03/-ГА

Хэрлэн сум 2020 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа
Утас: 70562147 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг
Утас: 70562147 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхтүвшин
Утас: 70562147 Цахим хаяг: enkhtuvshints@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛТЫН ХАНГАХАД СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ, БҮХ ШАТНЫ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.	
БҮЛЭГ 1. ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	8
А.1 ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙГ ТОГТВОРТОЙ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ.	8
А.1.1 “Боловсролын тухай” хууль, “Багшийн хөгжлийг дэмжих” тухай хуулийн зарим заалт хэрэгжихгүй байна.	8
А.1.2 Ерөнхий боловсролын талаарх яамны бодлого хөтөлбөрийг үр дүнгийг нь тооцож болохуйц хугацаанд хэрэгжүүлж байх шаардлагатай байна.	9
А.2 СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН, ХҮРТЭЭМЖТЭЙ МАТЕРИАЛЛАГ ОРЧИН БҮРДЭЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.	9
А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчин хангалттай бүрдэж чадаагүй байна.	9
А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин хангалттай биш байна.	12
А.2.3 Байгалийн шинэчлэл, гадаад хэл, мэргэжлийн чиг баримжаа олгох болон технологийн сургалтын мэргэжлийн багшийн хангамж дутагдалтай байна.	15
А.3 БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛ, ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАР, БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛД ХӨРӨНГӨ ДУТАГДАЖ БАЙНА. ..	18
А.3.1 Хувьсах зардлаар санхүүжих хүүхдийн тоог бодит бус мэдээлэлд тулгуурласнаас оны эцэст дахин хуваарилалт хийж төсвийг тодотгож байна.	18
А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардалд хөрөнгө дутагдаж байна.	20
БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛТ ХАНГАГДАЖ БАЙГАА Ч ТҮҮНД ХИЙГДЭЖ БҮЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	22
Б.1 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫГ “ЦӨМ” ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ БОЛОВСРУУЛСАН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ОЛГОЖ БҮЙ БОЛОВЧ СУРГАЛТЫН ЧАНАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ БОДИТОЙ БУС БАЙНА.	22
Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байна.	22
Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарт хийгдсэн БҮТ-ийн үнэлгээ бусад үнэлгээнээс хэт их бууралттай байна.	23
Б.2 БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ ХЭРЭГЖИЖ БҮЙ БОЛОВЧ ҮР ДҮНГ ЭРГЭН ХЯНАХ АЖИЛ ДУТУУ ХИЙГДЭЖ БАЙНА. ..	26
Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналт хэрэгжиж байгаа боловч үр дүнг тооцож, сайжруулах ажил хийгдэх нь дутмаг байна.	26
Б.2.2 Ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг аймгийн МХГ хэрэгжүүлж бусад байгууллагаас хийгдсэн хяналт байхгүй байна.	29
Холбогдох байгууллагын санал:	31
Саналд өгсөн тайлбар:	32
ДҮГНЭЛТ: 33	
ЗӨВЛӨМЖ: 34	
ХАВСРАЛТУУД:	36-44

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗТБХБ	Зам тээвэр, барилга, хот байгуулалт
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
ЦС	Цогцолбор сургууль
ХБУлаан	Хэрлэнбаян-Улаан
ЭМ	Эрүүл мэнд
БСУГ	Боловсрол, соёл урлагын газар
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НТБТ	Насан туршийн боловсрол төв
ЕБ	Ерөнхий боловсрол
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	<i>2017-2019 онд баригдсан өргөтгөлийн барилга, их засвар, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт</i>	12
Хүснэгт 2	<i>Багшийн хангалт /сумдаар/</i>	15
Хүснэгт 3	<i>Мэргэжлийн багшийн хангалт /төрлөөр/</i>	16
Хүснэгт 4	<i>“Цөм” хөтөлбөрийн хэрэгжилт /аймгийн хэмжээнд/</i>	23
Хүснэгт 5	<i>Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт /аймгийн хэмжээнд/</i>	24
Хүснэгт 6	<i>Давхардуулан тусгай зөвшөөрөл олгосон ЕБС-ийн судалгаа</i>	28

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	<i>Баян-Овоо сумын ЕБС-ийн дотуур байр</i>	11
Зураг 2	<i>Хэрлэн-1 ЕБС-ийн хичээлийн байр</i>	13
Зураг 3	<i>Мөрөн сумын ЕБС-ийн байр</i>	14
Зураг 4	<i>“Хан-Хэнтий” ЦС-ын байр</i>	14
Зураг 5	<i>Лазер зүсэгч</i>	15
Зураг 6	<i>3D принтер</i>	15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	<i>6-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт</i>	9
Дүрслэл 2	<i>ЕБС-ийн захирлын албан тушаалын шаардлага хангасан эсэх</i>	17
Дүрслэл 3	<i>ЕБС-ийн Сургалтын менежерийн албан тушаалын шаардлага хангасан эсэх</i>	18
Дүрслэл 4	<i>ЕБС-ийн төсвийн төслийн бүтэц</i>	19
Дүрслэл 5	<i>ТАБ-аас ЕБС-дын санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт</i>	21
Дүрслэл 6	<i>ТАБ-аас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн ангилал</i>	21
Дүрслэл 7	<i>Насан туршийн боловсрол болон дүйцсэн хөтөлбөрөөр суралцагч</i>	24
Дүрслэл 8	<i>БҮТ-ийн чанарын үнэлгээ /4 хичээлийн жилээр/</i>	26
Дүрслэл 9	<i>Дотоо хяналтын нэгжийн судалгаа</i>	27

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	<i>Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчны судалгаа /2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар/</i>	36-37
Хавсралт 2	<i>Ерөнхий боловсролын сургуулийн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хамран сургалтын судалгаа</i>	38-39
Хавсралт 3	<i>Ерөнхий боловсролын сургуулийн багш, боловсон хүчний судалгаа</i>	40-42
Хавсралт 4	<i>Төрийн өмчийн сургуулиудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн судалгаа</i>	43-44

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан <i>“Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”</i> -г үндэслэн уг гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	Улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар хийгдэж буй <i>“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”</i> гүйцэтгэлийн аудитын хүрээнд аймгийн хэмжээнд ерөнхий боловсрол олгож байгаа байдалд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: <ul style="list-style-type: none">➢ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх;➢ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн ЗДТГ, аймгийн БСУГ, ЭМГ, ГХБХБГ, ХХҮГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, төрийн болон хувийн өмчийн ЕБС-уудын 2016-2019 оны үйл ажиллагааг /2016-2017, 2017-2018, 2018-2019 буюу сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан аймаг дахь Төрийн аудитын газар гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 3 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Ц.Энхтүвшин хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс 31-ний хооронд хийж гүйцэтгэн, аудитыг гүйцэтгэх ажлыг 2020 оны 08 дугаар сарын 17-оос 10 дугаар сарын 12-ны өдрүүдэд, тайлагналын үе шатыг 2020 оны 10 дугаар сарын 13-аас эхлүүлж, тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2020 оны 11 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД СУМ, БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ ОЛГОЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙГ ТОГТВОРТОЙ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ.

А.1.1 “Боловсролын тухай” хууль, “Багшийн хөгжлийг дэмжих” тухай хуулийн зарим заалт хэрэгжихгүй байна.

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 8.2-т "Тодорхой хугацааны боловсролыг нөхөх, бие даан эзэмших зорилгоор бага, дунд боловсролыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр олгож болох бөгөөд уг хөтөлбөрийн агуулга, сургалт явуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр БСШУС-ын сайд 2018 онд А/168 дугаар тушаалаараа "Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр сургалт явуулах журам"-ыг баталсан байна. Журмын 5.2¹ дахь заалтыг баг, сумын Засаг дарга нар хангалттай хэрэгжүүлэхгүй байгаа тул бүх шатны Засаг дарга нарын ажлыг дүгнэх үзүүлэлтэд нэг үзүүлэлт болгон тусгах шаардлагатай.

Мөн журмын 6.3² заалт хэрэгждэггүй байна. Иймд аймаг, сумын ИТХ ирэх оны төсөв хэлэлцэхдээ албан бус сургалтад шаардлагатай зардлыг заавал хэлэлцэн ЕБС-ийн төсөвт тусган баталдаг байхаар "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-д тусгаж өгөх нь зүйтэй.

“Боловсролын тухай” хуулийн 18.5-д "энэ хуулийн 3.1.19 (өдөр өнжүүлэх үйлчилгээ)-т заасан үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", ЗТБХБ-ын сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар баталсан "ЕБС-ын барилгын төлөвлөлтийн дүрэм"-д 4.2-т зааснаар бага ангийн сурагчдад зориулсан "өдөр өнжүүлэх бүлгийн болон олон зориулалттай" ерөө байх шаардлагатай боловч анги танхимын хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хэрэгждэггүй байна.

Хуулийн 34.4."Энэ хуулийн 34.1-д заасан зөвлөл (Сургуулийн зөвлөл)-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр БСШУ-ны сайдын 2020 оны 230 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм" батлагдсан боловч бүрэн хэрэгжихгүй байна. Сургуулийн зөвлөл байгуулагддаг боловч хуульд заасан чиг, үүргээ хэрэгжүүлдэггүй байх тул зөвлөлийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийг "Боловсролын тухай" хуулийн аймаг, сумын ИТХ-ын бүрэн эрхэд нэмж өгөх нь зүйтэй юм.

Сургууль хөгжлийн сангийн талаар хуулийн 39.11."Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэсэн заалтыг хэрэгжүүлэхээр БСШУ-ны сайд, Сангийн сайдын 2008 оны 56/64 дүгээр тушаалаар "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм" батлагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

¹ 5.2-т "Хамран сургалт, захиргааны удирдлага, зохион байгуулалтаар хангах үүргийг бүх шатны Засаг дарга хүлээх бөгөөд сургалтын явц, чанар, үр дүн, хамрагдалтын талаар сургалт зохион байгуулагчаас гаргасан статистикийн мэдээллийг хянах чиг үүргийг аймаг, нийслэлийн Боловсролын газар тус тус гүйцэтгэнэ

² 6.3-т "Журмын 4.3-т заасан "танхимын сургалтаас бусад хэлбэрийн сургалтыг орон нутагт зохион байгуулахад шаардагдах нэмэлт зардал (унаа, шатахуун, багшийн томилго, урамшуулал, нүүдлийн үйл ажиллагааны бусад зардал зэрэг)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ"

“Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн 7.5-д заасан "Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэсэн заалтын дагуу журамлагдсан эрх зүйн акт гараагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

A.1.2 Ерөнхий боловсролын талаарх яамны бодлого хөтөлбөрийг үр дүнгийг нь тооцож болохуйц хугацаанд хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын талаарх бодлого хөтөлбөр батлагдан гардагч тогтвортой хэрэгжих үр дүнг харах боломж бага байдаг байна. Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сургалтын төлөвлөгөөнд ойр ойрхон өөрчлөлт орсон, сурагчдыг үнэлж дүгнэх журмын шинэчлэл нь багш нар заах хичээлийнхээ сэдэв хуваарилалтыг жил бүр өөрчлөх, ээлжит хичээлийн бэлтгэлийг хангах, мэдлэг, чадвар, төлөвшил, хандлагыг сурагч бүрээр үнэлэх, сурагчдыг түвшингээр үнэлэх, явцыг эцэг эхчүүдэд ойлгуулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан гаргахад бэрхшээл учирч байжээ.

Иймд бодлого, хөтөлбөрүүдийг удаан хугацаанд тогтвортой хэрэгжүүлж, үр дүнг олон жилийн дундажаар гаргах, шаардагдах хүний нөөц, хөрөнгийг хүрэлцэхүйц хэмжээнд баталж байхыг ЕБС-ийн багш нар хүсэж байна.


A.2 СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ БҮРЭН ХАНГАСАН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧИН, ХҮРТЭЭМЖТЭЙ МАТЕРИАЛЛАГ ОРЧИН БҮРДЭЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

A.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчин хангалттай бүрдэж чадаагүй байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсрол олгох сургалтын байгууллагууд дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг боловсруулдаг боловч нийт сургуулийн 88.9 хувь нь дээрхи төлөвлөгөөг аймаг сумын ИТХ-аар батлуулаагүй байгаа нь "Боловсролын тухай" хуулийн 29.1.2-д заасан заалтыг мөрдөөгүй байна.

Бор-Өндөр, Мөрөн, Норовлин сумын ЕБС-иуд "Сургууль хөгжүүлэх стратеги төлөвлөгөө"-гөө сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан боловч биелэлтэд ИТХ-аас хяналт хийгдсэн тухай мэдээлэл аудитад хамрагдсангүй.

Дүрслэл 1



“Сургууль хөгжүүлэх төлөвлөгөө”-гүй байх нь сургалтын байгууллагын хүний болон санхүүгийн нөөц дутагдах эрсдэлд хүрэх учир сургуулийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, сургуулийн зөвлөлөөр хэлэлцүүлэн аймаг, сумын ИТХ-аар батлуулж байх шаардлагатай юм.

Аймгийн хэмжээнд 2017-2019 оны дундажаар 6-17 насны 16652 хүүхэд байгаагаас 6-10 насны хүүхдийн 82 хувь, 11-14 насны хүүхдийн 81 хувь, 15-17 насны хүүхдийн 27 хувь нь ерөнхий боловсрол олгох сургалтанд хамрагджээ. 6-10 насны хүүхдүүдийнхээ 21-79 хувийг 10 сум, 11-14 насны хүүхдүүдийнхээ 18-79 хувийг сум ерөнхий боловсрол олгох сургалтад хамруулсан байна.

Ерөнхий боловсрол олгох сургалтад хамрагдалт бага байгаа нь сум, багийн Засаг дарга нар "Боловсролын тухай" хуулинд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлдэггүйтэй холбоотой юм. Хамран сургалтын шалтгаан нь 2020 оноос өмнө хамран сургах тойргийг тогтоогоогүй байснаас гадна аймгийн төв, Бор-Өндөр сум болон Багануур дүүрэгт хүүхдээ сургахдаа гэр бүлийн нэг нь шилжилт хийлгэдэг боловч хүүхдэдээ 180 хоногоос дээш хугацаагаар байнга оршин суух бүртгэл хийлгэдэггүй байна.

Иймд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух 16 хүртэлх насны хүүхдийн бүртгэлийг сайжруулах шаардлагатай.

Хамран сургалтын нэг чухал нөхцөл бол сурагчдын дотуур байрны хүрэлцээ, тохь тух, хангамж юм. Аймгийн хэмжээнд 23 ЕБС нийт 1652 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны барилгатай байгаагийн 8 нь зориулалтын бус барилгатай байна. Дотуур байрны 13 нь нэгдсэн халаалтын системд холбогдож хүүхэд амьдрах таатай орчин бүрдсэн байна.

Хичээлийн байрны танхимыг засварлан дотуур байрны үйлчилгээнд ашиглаж байгаа Баянхутаг, Дархан сумын ЕБС-ууд, зориулалтын бус барилгатай Мөрөн, Норовлин сумын ЕБС, Тэмүүжин ЦС-д дотуур байрны зориулалтын барилга нэн тэргүүнд шаардлагатай байна. Батширээт, Биндэр, Дэлгэрхаан сумын ЕБС-ийн дотуур байр түр орон сууцны зориулалттай БАМ-ын барилгыг ашигладаг ба цаашид зориулалтын барилга шаардлагатай болох юм.

Аймгийн хэмжээнд нийт дотуур байрны нийт хүчин чадлын 78 хувийг ашиглаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

- *Дотуур байрны хүчин чадлыг Баян-Адрага сумын ЕБС 28 хувь, Биндэр сумын ЕБС 34 хувь, Дадал сумын ЕБС 29 хувь, Дэлгэрхаан сумын ЕБС 11 хувь, Цэнхэрмандал сумын ЕБС 6 хувь, Хэрлэн ЕБС-1 52 хувь, Тэмүүжин ЦС 43 хувиар хэтрүүлэн ашиглаж байжээ.*
- *Харин дотуур байрны хүчин чадлыг Баян-Овоо сумын ЕБС 20 хувь, Бор-Өндөр сумын ЕБС 58 хувь, Галшар сумын ЕБС 40 хувь, Жаргалтхаан сумын ЕБС 59 хувь, Норовлин сумын ЕБС 65 хувь, Өмнөдэлгэр сумын ЕБС 53 хувь, Хурх тосгоны ЕБС 31 хувь, Өлзийт тосгоны ЕБС 60 хувиар ашиглаж байсан нь хангалтгүй үзүүлэлт юм.*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Баян-Адрага суманд 100, 2018 онд Баян-Овоо суманд 150, 2019 онд Дадал суманд 150 хүүхдийн дотуур байр баригдаж тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, 2020 онд Бэрх тосгонд 150 хүүхдийн дотуур байрны барилгыг ашиглалтад оруулахаар барьж байна.



Баян-Овоо суманд баригдсан 150 хүүхдийн дотуур байр нь шаардагдах хүчин чадлыг оновчтой тодорхойлж чадаагүйгээс ашиглалт хангалтгүй байгаа нь өндөр зардалтай, үр ашиг муутай хөрөнгө оруулалт болжээ.

Зураг 1

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд Хан Хэнтий ЦС-ийн дотуур байранд 4.3 сая төгрөг, 2018 онд Хэрлэн-1 ЕБС-ийн дотуур байранд 58.5 сая төгрөгийн дээврийн засвар хийгдсэн ба ашиглалтын шаардлага хангаж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017-2019 онуудад Дархан сумын дотуур байранд 11.0 сая төгрөгийн урсгал засвар хийгдснээс гадна Батширээт суманд 18.6 сая төгрөг, Баянмөнх суманд 6.0 сая төгрөг, Галшар суманд 4.0 сая төгрөг, норовлин суманд 19.0 сая төгрөг, Өмнөдэлгэр суманд 10.0 сая төгрөг, Өлзийт тосгонд 3.5 сая төгрөг, нийт 61.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж бэлтгэсэн ба ашиглалтын шаардлага хангаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зориулалттай нийт 15 барилга нь хүүхэд амрах нийт ерөө 256 байгаа бөгөөд нэг ерөөнд дундажаар 4 хүүхэд амьдарч байна.

- *Нэг ерөөнд амьдрах дундаж хүүхдийн тоогоор "Хан Хэнтий" ЦС-ийн дотуур байранд 9, Хэрлэн-1, Өлзийт тосгоны ЕБС-ын дотуур байранд 6 хүүхэд ногдож байгаа нь бусдаас өндөр үзүүлэлт юм.*
- *Хурх, Өлзийт тосгон, Хан Хэнтий ЦС-ийн дотуур байранд хүүхэд амьдардаггүй ерөөний зориулалтыг өөрчлөн ашиглаж байгаа цаашид дотуур байрны зохиомол хомсдолд хүргэх эрсдэлтэй байна.*

ЕБС-ийн бүх дотуур байр хүүхэд амрах ерөөтэй ба Хэрлэн-1, Хэрлэн-4, Батноров, Бор-Өндөр, Цэнхэрмандал сум, Өлзийт, ХБУлаан тосгоны ЕБС-ын дотуур байр эрүүл мэндийн ерөөгүй, Жаргалтхаан, Хэрлэн-1, Хэрлэн-4 дүгээр сургууль, ХБУлаан тосгоны ЕБС-ийн дотуур байр уншлагын заал бүхий номын сангүй, Хэрлэн-4, Өлзийт, Хэрлэнбаян Улаан тосгоны ЕБС-ийн дотуур байр халуун усны шүршүүргүй, Өлзийт, Хэрлэнбаян Улаан тосгоны ЕБС-ийн дотуур байр дотор ариун цэврийн суултуургүй байгаагаас хүүхдийн амьдрах тохь тухтай орчинг бүрэн бүрдүүлж чадаагүй байна.

Шаардлагатай ерөө, танхимыг тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангахад төрөл бүрийн эх үүсвэрийг ашиглан хөрөнгө оруулалтыг хийхэд ЕБС-ийн захирлын санаачлага, шат, шатны Засаг даргын дэмжлэг нэн чухал шаардлагатай юм.

Ерөнхий боловсролын сургуулийн нийт 23 дотуур байрны 20 нь 678 суудалтай хоолны газартай ба Бэрх тосгон, Баянхутаг, Дархан, Норовлин, Цэнхэрмандал, Хэрлэн-4 дүгээр сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдүүд сургуулийн хоолны зааланд, Мөрөн сумын дотуур байрны хүүхдүүд амьдрах ерөөндөө хооллож байгаа нь амьдрах орчины нөхцөл байдалд тохирохгүй, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй нөхцөлд хооллож байна.

А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин хангалттай биш байна.

Аймгийн хэмжээнд төрийн өмчит ЕБС 25, хувийн хэвшлийн ЕБС 1, насан туршийн боловсролын төв 1 ажиллаж байна. Жаргалтхаан, Мөрөн, Насан туршийн боловсролын төв зориулалтын бус хичээлийн байранд үйл ажиллагаагаа зохион байгуулдаг ба нийт ЕБС-иудын 19 нь нэгдсэн халаалтын системд холбогдсон байна. Зориулалтын бус барилгатай Жаргалтхаан ЕБС, дотуур байрны зориулалтай барилгад бага анги хичээллэж байгаа Өмнөдэлгэр ЕБС-д хичээлийн зориулалтын барилга нэн чухал шаардлагатай болжээ.

Аймгийн хэмжээнд 26 ЕБС нийт 13708 хүүхдийн хүчин чадалтай 42 хичээлийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хүчин чадлын ашиглалт 97 хувьтай байна.

- *Сургуулийн хичээлийн байрны хүчин чадлыг Батноров ЕБС 92 хувь, Баян-Адрага ЕБС 54 хувь, Биндэр ЕБС 18 хувь, Бор-Өндөр ЦС 73 хувь, Жаргалтхаан ЕБС 41 хувь, Өмнөдэлгэр ЕБС 51 хувь, Хан Хэнтий ЦС 46 хувиар хэтрүүлэн ашиглаж байжээ.*
- *Харин сургуулийн хичээлийн барилгын хүчин чадлыг Батширээт ЕБС 56 хувь, Баянмөнх ЕБС 68 хувь, Баянхутаг сум 32 хувь, Галшар сум 61 хувь, Дархан ЕБС 51 хувь, Хэрлэнбаян Улаан 59 хувь, Хурх 31 хувь, Цэнхэрмандал 72 хувь, Өлзийт 74 хувьтай ашиглаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.*

Насан туршийн боловсролын төв нь Политехникийн коллежийн актлагдсан байранд түр байрлаж байгаа ба насан туршийн боловсрол олгоход зориулагдсан бие даасан байгууламжид үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд Батширээт суманд 320, Хэрлэн суманд 928, 2018 онд Биндэр суманд 640 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн шинэ барилга ашиглалтад орж сургуулийн байрны тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байна.

Гэвч Батширээт сумын ЕБС-ийн 240 хүүхдийн модон барилгыг актлаагүйгээс одоогийн байдлаар нийт 560 хүүхдийн хүчин чадалтай 2 барилгатай болж хүчин чадлын ашиглалт 56 хувь болж буурч байна. Иймд сургалтад ашиглагдахгүй болсон барилгын зориулалтын өөрчлөлтийг өмчийн бүртгэлд тухай бүрт бүртгүүлж байх нь зүйтэй.

Мөн Бор-Өндөр сумын ЕБС нь “Монголросцветмет” нэгдлээс шилжүүлэн авсан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2019 онуудад баригдсан 738.2 сая төгрөгийн өртөгтэй өргөтгөл барилга, 957.0 сая төгрөгийн их засварын ажил, 52.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын үр дүн сайн, ашиглалтын шаардлага хангаж байна.

Хүснэгт 1

	Сургуулийн нэр	Хөрөнгийн зориулалт	Өртөг (сая.төг)
1	Баянхутаг сумын ЕБС	Спорт заалны өргөтгөл	689.0
2	Жаргалтхаан сумын ЕБС	Урлаг заалны өргөтгөл	49.2
3	Бэрх тосгоны ЕБС	Кабинетийн засвар	15.0
4	Баян-Овоо сумын ЕБС	Дээвэр, дотор засал	161.2
5	Галшар сумын ЕБС	Спорт заалны засвар	224.9
6	Өмнөдэлгэр сумын ЕБС	Хичээлийн байрны засвар	78.5
7	Хурх тосгоны ЕБС	Дээврийн засвар	189.6
8	Тэмүүжин ЦС	Дээвэр, шал, халаалтын засвар	104.9
9	Хэрлэн ЕБС-4	Дээврийн засвар	182.9
10	Биндэр сумын ЕБС	Мэдээлэл зүйн танхим	20.0
11	Дэлгэрхаан сумын ЕБС	Тоног төхөөрөмж	13.0
12	Мөрөн сумын ЕБС	Шатрын танхим	19.9

Аймгийн хэмжээнд нэг ангид ногдох дундаж хүүхдийн тоо бага ангид 23, дунд ангид 21, ахлах ангид 23 хүүхэд байна. Аудитад хамрагдсан хугацааны дундаж үзүүлэлтээр нэг

ангид ногдох хүүхдийн тоогоор 12 ЕБС-ийн бага анги, 9 ЕБС-ийн дунд анги, 8 ЕБС-ийн ахлах ангийн хүүхдийн тоо аймгийн дундажаас бага байна. Ялангуяа Баянхутаг, Хэрлэнбаян Улаан, Мөрөн, Хурх, Өлзийт тосгоны ЕБС-ийн нийт анги, Галшар, Дархан сумын ЕБС-ийн дунд анги, Бэрх тосгоны ЕБС-ийн ахлах ангийн хүүхдийн тоо харьцангуй бага байгаа нь анхаарал татаж байна.

Аймгийн хэмжээнд ЕБС-иуд нийт 451869 м.кв талбай бүхий эдэлбэр газартай ба дундажаар нийт талбайн 5 хувийг ногоон байгууламж эзэлж байгаа нь Зам, тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар батлагдсан "ЕБС-ийн барилгын төлөвлөлтийн дүрэм"-ийн 3.6-д заасан шаардлагыг хангахгүй байна.

Иймд ЕБС-ийн хөгжлийн төлөвлөгөөнд "нийт эдэлбэр газрын 50%-иас багагүй талбай нь ногоон байгууламж байх" зорилтыг заавал тусгаж, хэрэгжилтэд нь сумын Засаг дарга хяналт тавьж биелэлтийг хангуулж байх шаардлагатай.

Аймгийн хэмжээнд 6 настан хичээлэх 38, 2-5 дугаар анги хичээлэх 142, дунд анги хичээлэх 145, ахлах анги хичээлэх 69 танхимтай байна. Гэвч 6 настны ангид амрах өрөө, 2-5 дугаар ангийн "өдөр өнжүүлэх өрөө" тус бүр 2 байгаа боловч бусад ангиуд дээрхи зориулалтын өрөөгүй байгаа нь бага ангийн хүүхдийн сурах таатай орчинг бүрэн хангаж чадаагүй байна.

Зургаан настны амрах өрөө, бага ангийн хүүхдийн өдөр өнжүүлэх бүлгийн зориулалтын өрөөг бий болгоход ЕБС-иуд захирал, сумын Засаг дарга нарын санаачлага, дэмжлэг туслалцаа нэн чухал шаардлагатай байна.

Сургалт зохион байгуулах зориулалттай хичээлийн байр бүхий 24 ЕБС-ийн хувьд физикийн кабинет 12, химийн кабинет 10, биологийн кабинет 10, газар зүйн кабинет 12 байгаа нь байгалийн ухааны сургалт зохих түвшинд зохион байгуулагдахгүй байгаатай холбоотой. Байгалийн ухааны сургалтад зориулагдсан багаж, тоног төхөөрөмжийн хангалт зарим ЕБС-дад хангалтай байж чадахгүй байна. Тусгай тоноглол бүхий гадаад хэлний танхим 1, техникийн шугам зургийн танхим 3 байгаагаас эдгээр хичээлүүдийг сурах бичиг, сурагчийн хувийн хичээлийн хэрэгсэлд тулгуурлаж заадаг ба сургах орчинг бүрдүүлж чадаагүй байна. Мөн 11 ЕБС хөдөлмөрийн дадлага олгох кабинет, материал боловсруулах кабинеттай, багаж, тоног төхөөрөмж бүрэн хангагдаж чадаагүйгээс суралцагчдад хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалт хангалттай явагдахгүй байна.

ЕБС бүрт физик, химийн лабораторийн өрөө, биологи, газар зүйн танилцах танхим, мэргэжлийн дадлага олгох болон технологийн өрөөтэй болох зайлшгүй шаардлагатай тул "Сургууль хөгжүүлэх төлөвлөгөө"-д тусган, хэрэгжилтийг бүрэн хангах нь зүйтэй.



Зураг 2

Ерөнхий боловсролын 26 сургууль нийт 462 суудал бүхий уншлагын заал бүхий номын сан, үзвэр үзэх 7 заал, дуу хөгжмийн 13, нийтээр дуулах, бүжиглэх сургалтын 3, уран зураг зурах 5 өрөөтэй байгаа нь хичээлээс гадуурхи сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулах, хүүхдийн авъяасыг хөгжүүлэх нөхцөл бололцоо хангалттай биш байна.

Ерөнхий боловсрол олгож байгаа 21 сургалтын байгууллагын эдэлбэр газар, түүний орчны аюулгүй байдал сайн байна. Харин Баянмөнх сумын ЕБС-ийн шатсан БАМ-ын барилгын суурь, Галшар сумын ЕБС-ийн зарагдсан БАМ-ын барилгыг нурааж зайлуулаагүй, Хэрлэн-1, "Хан Хэнтий" ЦС-ийн хашааны хаалганд тулгаж авто зам барьсан, "Тэмүүжин" ЦС-ийн бага сургууль автомашины зогсоолгүй байгаа нь зам тээврийн осол гарах эрсдэлтэй орчин бүрдсэн байна.

Мөн Мөрөн сумын холбооны антени ЕБС-д хэт ойр байрлалтайгаас 2018 онд аянга бууж интернетийн сүлжээг дордуулсан боловч одоог хүртэл хохирлыг барагдуулаагүй байна.



Зураг 3



Зураг 4

Ерөнхий боловсролын 15 сургууль 737 суудал бүхий цайны газартай ба хоолны заалны угаалтууртай, бүгд хүнс хадгалах өрөөтэй байна. Харин Баянмөнх, Баян-Овоо, Галшар, Дадал, Хэрлэнбаян Улаан, Жаргалтхаан, Мөрөн, Өмнөдэлгэр, Хурх тосгоны ЕБС, Хан Хэнтий ЦС-дын хичээлийн байр цайны газаргүйгээс дотуур байрны хоолны газарт "үдийн цай"-гаа бэлтгэдэг нь тогоочийн ачааллыг нэмэгдүүлдэг байна.

Иймд БСШУ, ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 дугаар тушаалаар батлагдсан "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд мөрдөх журмын 1.2 заалтын дагуу аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах, дотуур байрны хоолны газар, хичээлийн байрны цайны газар тусдаа бол цайны газрыг аж ахуйн нэгжид түрээслэх гэрээний үндсэн дээр "Үдийн цай" олголтыг зохион байгуулж, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлбэл хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Сургуулийн өмч хөрөнгийн тооллогын дүнгээс харахад аймгийн хэмжээнд 6 настанд зориулагдсан ширээний 31 хувь, сандалын 32 хувь, сурагчийн ширээ 34 хувь, сандалын 34 хувь шаардлага хангахгүй байна.

Сурагчийн ширээ, сандалын хангамжийг сайжруулахад орон нутаг дахь жижиг модон эдлэлийн цех, мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвийн чадавхад тулгуурласан бодлогыг аймгийн түвшинд боловсруулан, хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

ЕБС-иудын 26 хувь нь буюу Батноров сумын ЕБС 13, Баян-Адрага сумын ЕБС 15, Бор-Өндөр сумын ЕБС 25, Дадал сумын ЕБС 13, Жаргалтхаан сумын ЕБС 24, Хурх тосгоны ЕБС 12, Цэнхэрмандал сумын ЕБС 12 хүний суудалтай сурагчдын тээврийн хэрэгсэлтэй байна. Цаашид ЕБС-иуд тээврийн хэрэгслийг худалдан авахаар төлөвлөхдөө сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлыг тооцож төсөвт тусгаж байх нь зүйтэй юм.

Хэрлэн-4, Тэмүүжин ЦС-д нийлүүлэгдсэн лазер зүсэгч нь хэвийн бус үнэрт хий ялгаруулдаг, 3D хэвлэгчийн эд анги битүүмжлэгдээгүй, ил байгаа нь сургалтанд ашиглах боломжгүй байна.



Зураг 5


Зураг 6

А.2.3 Байгалийн шинэчлэл, гадаад хэл, мэргэжлийн чиг баримжаа олгох болон технологийн сургалтын мэргэжлийн багшийн хангамж дутагдалтай байна.

Аймгийн хэмжээнд дундажаар 293 бага ангийн багш шаардлагатай байжээ. 2017-2019 онуудад дундажаар 277 багш ажиллаж байсан ба бага ангийн багшийн хангалт аймгийн хэмжээнд 93 хувьтай байна. Баянмөнх, Дадал, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумын ЕБС, Хэрлэн-1, Тэмүүжин ЦС болон "Насан туршийн боловсрол" төвийн бага ангийн багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.

Гадаад хэл, мэргэжлийн болон технологийн сургалтыг группээр, бага ангийн дурслэх урлаг, дуу хөгжим, биеийн тамир болон англи хэлний хичээлийг мэргэжлийн багшаар заалгахаар тооцвол аймгийн хэмжээнд дундажаар 604 мэргэжлийн багш шаардлагатай байна. 2017-2019 онд дундажаар 471 багш ажиллаж байсан ба мэргэжлийн багшийн хангалт аймгийн түвшинд 75 хувьтай байна.

Хүснэгт 2



Батширээт, Баянмөнх, Баянхутаг, Бор-Өндөр, Дархан, Дэлгэрхаан, Хэрлэнбаян Улаан, Жаргалтхаан, Норовлин сумын ЕБС, Хэрлэн ЕБС-1, Өлзийт тосгоны ЕБС

болон "Насан туршийн боловсрол" төвийн багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна. Насан туршийн боловсролын төв, Дэлгэрхаан, Жаргалтхаан сумын ЕБС-уудын мэргэжлийн багшийн хангалт бусад сургуулиудтай харьцуулахад харьцангуй бага байгааг цаашид аймгийн БСУГ анхаарах шаардлагатай.

Багшийн хангалтыг мэргэжил бүрээр нь авч үзвэл

- Эх хэлний багшийн хангалт аймгийн хэмжээнд 85 хувьтай байна. Батноров, Батширээт, Баянмөнх, Биндэр, Бор-Өндөр, Дэлгэрхаан, Хэрлэнбаян Улаан, Жаргалтхаан сумын ЕБС-ууд, Хэрлэн-1, Хэрлэн ЕБС-4 болон "Насан туршийн боловсрол" төвийн эх хэлний багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.
- Гадаад хэлний сургалтыг группээр хичээллүүлэн, 5 дугаар ангийн англи хэлний хичээлийг мэргэжлийн багшаар заалгахад аймгийн хэмжээнд дундажаар 135 багш шаардлагатай боловч аудитад хамрагдсан байдлаар гадаад хэлний багшийн хангалт аймгийн хэмжээнд 54 хувьтай байна. Батноров, Бэрх, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хурх, Цэнхэрмандал, Хэрлэн-1, Өлзийт тосгоны ЕБС болон "Насан туршийн боловсрол" төвийн гадаад хэлний багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.
- Математик мэдээлэл зүйн багшийн хангалт аймгийн түвшинд 97 хувьтай байна. Баян-Адрага, Бор-Өндөр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Норовлин сумын ЕБС-ууд болон "Насан туршийн боловсрол" төвийн математик, мэдээлэл зүйн багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.

Хүснэгт 3



- Байгалийн ухааны багшийн хангалт аймгийн хэмжээнд 93 хувьтай байна. Батноров, Батширээт, Баян-Овоо, Биндэр, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Норовлин, Хэрлэн-1, Өлзийт тосгоны ЕБС болон "Насан туршийн боловсрол" төвийн байгалийн ухааны багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.
- Нийгмийн ухааны багшийн хангалт аймгийн хэмжээнд 121 хувьтай байна. Батноров, Бэрх, Бор-Өндөр, Өмнөдэлгэр, Хэрлэн-1, Хан Хэнтий ЦС, Тэмүүжин ЦС, Хэрлэн-4 дүгээр сургуулиудын нийгмийн ухааны багшийн хангалт аймгийн түвшингээс дээгүүр байна.
- Бага ангийн дуу хөгжим болон биеийн тамирын хичээлийг мэргэжлийн багшаар заалгахаар тооцоход аймгийн хэмжээнд 98 багш шаардлагатай байгаа ба

багшийн хангалт аймгийн түвшинд 83 хувьтай байна. Бэрх, Баянмөнх, Баянхутаг, Бор-Өндөр, Галшар, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Норовлин, Хан Хэнтий ЦС, Өлзийт тосгон ЕБС болон "Насан туршийн боловсролын төвийн дуу хөгжим, биеийн тамирын багшийн хангалт аймгийн түвшингээс доогуур байна.

- Дунд, ахлах ангийн дүрслэх урлаг, дизайн зураг зүй, технологийн хичээлийг группээр хичээлэхээр тооцвол аймгийн хэмжээнд 74 багш шаардлагатай байгаа бөгөөд багшийн хангалт 84 хувьтай байна. Бага ангийн дүрслэх урлаг, технологийн хичээлийг ангийн багш заадаг байна. Батноров, Бэрх, Батширээт, Биндэр, Бор-Өндөр, Дадал, Норовлин, Хэрлэн ЕБС-1, Тэмүүжин ЦС, Хэрлэн ЕБС-4, Өлзийт тосгоны ЕБС болон Насан туршийн боловсролын төвийн багшийн хангалт аймгийн дундажаас доогуур байна.

Насан туршийн боловсролын төсвөөс бусад ЕБС-иуд "Багшийн хөгжлийн төв" байгуулан багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулж байна. Багшийн хөгжлийн төвийн нэг суудалд ногдох багшийн тоо аймгийн дундажаар 2 байна. Хэрлэн ЕБС-4 дүгээр сургуулийн багшийн хөгжлийн төвийн нэг суудалд ногдох багшийн тоо 4 байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Багшид зориулагдсан компьютерээр бүрэн хангагдсан боловч ашиглалтын хугацаа дууссан, технологийн хоцогдолд орсон байна. "Багшийн хөгжлийн төв"-өөр дамжуулан 2019 онд нийт 185 мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөгдөж, 19.4 сая төгрөг зарцуулжээ.

"Багшийн хөгжлийг дэмжих тухай" хуулийн 7.2-т "Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага нь бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө" гэсэн заалт хэрэгжих боломж муутай байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутамд мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2017-2019 онд нийт 198 багш суралцжээ. Энэ нь нийт багш нарын 26 хувьтай тэнцэж байна.

Англи хэлийг нийт багш нарын 13 хувь нь дунд түвшинд, 4 хувь нь ахисан түвшинд эзэмшсэн байна. Англи хэлний түвшин ахиулах сургалтыг эрчимжүүлэх ажлыг нийт багш нарын хүрээнд далайцтай зохион байгуулах нэн чухал шаардлага бий болсон байна.

БСШУС-ын сайдын 2019 оны А/692 тушаалаар ЕБС-ийн захирал, сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүргийг баталсныг шалгуур үзүүлэлт болгон сургуулийн захирал, менежерүүдийг шалгуурт нийцэж байгаа эсэхийг тодорхойллоо.



Сургуулийн захирлуудын хувьд бүгд багшийн мэргэжилтэй боловч мэргэшлийн хувьд 18 нь тэнцэхгүй байна. Багшилсан жилийн шаардлагыг 8 хүн хангахгүй байгаа боловч 5 нь ЕБС-ийн удирдах албан тушаалд 10-29 жил ажилласан туршлагатай байна. Баян-Адрага, Бор-Өндөр, Галшар, Дэлгэрхаан, Хэрлэнбаян Улаан, Цэнхэрмандал, Хэрлэн-4, Өлзийт тосгоны ЕБС-ийн захирлууд тухайн албан тушаалд тавигдах ажлын туршлага, Бор-Өндөр, Хэрлэн-4 сургуулийн захирлуудын багшилсан жил

Дүрслэл 2

шаардлага хангахгүй байна. Цаашид ЕБС-ийн захирлуудыг боловсрол, нийгэм, төрийн удирдлага, боловсрол судлалын чиглэлээр мэргэшүүлэх шаардлагатай.

Аймгийн хэмжээнд нийт 42 сургалтын менежер ажиллаж байгаагийн 2 нь багшийн бус мэргэжилтэй ч сурган заах аргын сургалтанд хамрагдаж, багшлах эрх аваад 12-16 жил багшилсан туршлагатай байгаагаас гадна 32 нь мэргэшлийн хувьд тэнцэхгүй байна. Багшилсан жилийн шаардлагыг 9 хүн хангахгүй байгаа боловч 5 хүн 7-15 жил сургалтын менежер, ЕБС-ийн захирал, БСУГ-т мэргэжилтнээр ажилласан туршлагатай байна. ЗАН-ийн ахлагчаар ажилласан жилийн хувьд 21 нь тэнцэхгүй байгаа боловч 14 нь сургалтын менежер, БСУГ-ын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, даргаар 4-19 жил ажилласан туршлагатай байна. Баян-Овоо, Биндэр, Бор-Өндөр, Хэрлэнбаян Улаан, Хэрлэн-4 дүгээр сургуулиудын 7 сургалтын менежер тухайн албан тушаалд тавигдах ажлын туршлагын хувьд шаардлага хангахгүй байна. Цаашид ЕБС-ийн сургалтын менежерүүдийг боловсрол судлалын чиглэлээр мэргэшүүлэх шаардлагатай.



Дүрслэл 3

Хичээлийн барилга нь 500 хүүхдийн хүчин чадалтай "Хан Хэнтий" ЦС-д сургалтын менежер 3 ажиллаж байгаа нь БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"-т заасан бүрэн дунд боловсрол олгох ЕБС-ийн сургалтын менежерийн орон тооноос хэтэрсэн байна.

ЕБС-дад 26 нийгмийн ажилтан ажиллаж байгаа ба 8 нь мэргэжлийн хувьд шаардлага хангахгүй байгаа ч 4-15 жил ЕБС-ийн нийгмийн ажилтнаар ажилласан туршлагатай байна. Цаашид нийгмийн ажилтны мэргэжлийг дээшүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай. Хичээлийн барилга нь 920 хүүхдийн хүчин чадалтай Хэрлэн-4 ЕБС-д нийгмийн ажилтан 2 ажиллаж байгаа нь БСШУС-ын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив"-т заасан бүрэн дунд боловсрол олгох ЕБС-ийн нийгмийн ажилтны орон тооноос хэтэрсэн байна.

А.3 БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛ, ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАР, БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛД ХӨРӨНГӨ ДУТАГДАЖ БАЙНА.

А.3.1 Хувьсах зардлаар санхүүжих хүүхдийн тоог бодит бус мэдээлэлд тулгуурласнаас оны эцэст дахин хуваарилалт хийж төсвийг тодотгож байна.

Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд 2017-2019 онд аймгийн хэмжээнд дунджаар жилд 18906.2 сая төгрөгийн төсөв шаардлагатай байгаагийн 91.7



хувийг бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээнд, 7.6 хувийг дотуур байрны үйлчилгээнд, 0.8 хувийг албан бус хэлбэрээр боловсрол олгох үйлчилгээнд, 0.4 хувийг орой, эчнээ сургалтаар бага, суурь боловсрол олгох үйлчилгээнд, үлдэх хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд зориулагдсан бага, суурь боловсролын үйлчилгээнд зориулахаар төсвийн төсөл боловсруулжээ.

Дүрслэл 4

Боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар тооцсон 2017-2019 онуудын дундаж төсвийг нормативаар байвал зохих төсөвтэй харьцуулахад аймгийн хэмжээнд 7 хувиар хэтрүүлэн тооцсон байна.

Харин "Насан туршийн боловсролын төв"-ийн зардлыг тооцох тодорхой аргачлал байхгүй байна. Энэ нь санхүүжих дундаж хүүхдийн тоог буруу тооцох, 2017, 2018 онуудад хувьсах зардлын дундаж нормативийг сонгохдоо байршил, сургуулийн ангиллыг буруу тооцсоноос шалтгаалсан байна.

Орон нутгийн санаачлагаар 2018 онд хийсэн "Хэнтий аймгийн боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар төлөвлөлтийн талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч 2019 онд санхүүжих хүүхдийн тоог тооцохдоо оны эхний 6 сарын төсвийг "2018-2019 оны хичээлийн жил", сүүлийн 6 сарын төсвийг "2019-2020 оны хичээлийн жил"-д суралцах хүүхдийн тоонд тулгуурласан нь үндэслэл муутай байна.

Төсөв боловсруулж буй жилийн санхүүжих хүүхдийн тоог тооцохдоо өмнөх 3 хичээлийн жилд суралцаж байсан хүүхдийн тооны дундаж, өсөлтийн хурдаас хамааруулан тооцвол бодит байдалд нийцэхээр байна.

Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлаас эм бэлдмэл-эмнэлэгийн хэрэгсэл, хог хаягдал зайлуулахад зардал хуваарилдаггүй боловч бусад хувьсах зардлын бүрэлдэхүүнд нь багтдаггүй бага үнэтэй түргэн элэгдэх бараа авах, урсгал засвар хийх, биеийн тамирын уралдаан тэмцээнд оролцох, шагнал урамшуулалын зардалд нийтдээ 2017, 2018 онуудад бусад хувьсах зардлын 35.0 хувийг, 2019 онд 24.3 хувийг хуваарилсан байна. Энэ нь бусад хувьсах зардлын хүртээмжийг бууруулж, шаардагдах хөрөнгө дутагдахад хүргэсэн байна.

ЕБС-иудын боловсруулсан төсвийн төсөлд жилд дунджаар 11.0 сая төгрөгийн ном хэвлэлийн зардал шаардлагатай гэж тусгасныг аймгийн БСУГ бусад хувьсах зардалд ном

хэвлэлийн зардлын эзлэх хувийг 2017, 2018 онуудад 4 хувь, 2019 онд 5.3 хувь байхаар тогтоожээ. Энхүү тогтоосон хувиар тооцвол аймгийн хэмжээнд ном, хэвлэлийн зардалд 9.9 сая төгрөг шаардлагатай байгаа бөгөөд ЕБС-иуд байвал зохих хэмжээнээс 1.1 сая төгрөг илүү төсөвлөж, 8.6 сая төгрөг зарцуулсан нь ном хэвлэлийн зардлын хувь хэмжээг аймгийн БСУГазар нь бодит хэрэгцээнд тулгуурлан тогтоосон байна гэж үзэхээр байна.

ЕБС-иудын боловсруулсан төсвийн төсөлд жилд дунджаар 99.9 сая төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал шаардлагатай гэж төсөвлөжээ. Аймгийн БСУГ бусад хувьсах зардалд хичээл, үйлдвэрлэл дадлагын зардлын эзлэх хувийг 2017,2018 онуудад 35.0, 2019 онд 44.1 хувь байхаар тогтоожээ. Энэхүү хувиар тооцвол аймгийн хэмжээнд 85.3 сая төгрөг шаардлагатай байгаа бөгөөд ЕБС-иуд байвал зохих хэмжээнээс 14.6 сая төгрөгөөр илүү төсөвлөж, 244.6 сая төгрөг зарцуулсан нь хичээл, үйлдвэрлэл дадлагын зардлын хувь хэмжээг аймгийн БСУГ нь бодит хэрэгцээнээс багаар тогтоосон байна гэж үзэхээр байна.

Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн болон аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтоох “Боловсролын тухай” хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

ЕБС-иуд нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг төсөвлөхдөө Засгийн газрын 2016 оны 242 дүгээр тогтоолыг дагуу боловсруулж байна.

Аймгийн хэмжээний ЕБС-дын боловсруулсан төсвийн төсөл болон батлагдсан төсөв нь аймгийн нийт дүнд эзлэх хувиар илэрхийлбэл Бор-Өндөр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Хурх, Хэрлэн-1, Тэмүүжин ЦС-ийн төсвийг 0.02-1.31 хувиар өсгөж хуваарилжээ.

Оны эцэст Батноров, Батширээт, Өмнөдэлгэр, “Хан Хэнтий” ЦС, “Тэмүүжин” ЦС, Хэрлэн-4 дүгээр сургууль, Өлзийт тосгоны ЕБС-иудын төсвийг бууруулж, Бэрх, Баянмөнх, Баян-Овоо, Биндэр, Бор-Өндөр ЦС, Дархан, Жаргалтхаан, "Их ирээдүй" сургууль болон Насан туршийн боловсролын төвийн төсвийг нэмэгдүүлж байгаа нь төсвийн хуваарилалтыг оновчтой, тэгш хүртээмжтэй хийж чадахгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч хангамж, бараа материал, эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардалд хөрөнгө дутагдаж байна.

Бүх нийтийн ерөнхий боловсрол олгоход 2017-2019 онд дундажаар аймгийн хэмжээнд нийт 18795.2 сая төгрөг батлагдаж төсвийн тодотголоор дундажаар 0.4 хувиар нэмэгдэж байсан байна. Жилд дундажаар 19434.4 сая төгрөгийг боловсролын үйлчилгээнд зарцуулж байсан нь батлагдсан төсвийн 99.8 хувийг эзэлж байна.

Ерөнхий боловсрол олгож байгаа 27 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар 2017, 2018, 2019 онуудад давхардсан тоогоор нийт 69 "Зөрчилгүй", 1 "Хязгаарлалттай"




Дүрслэл 5

санал дүгнэлт авч, 7 ЕБС-д "Итгэл" үзүүлж, 4 ЕБС-ийг сумын төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хамруулсан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 297,4 сая төгрөгийн зөрчил илэрсний 23.4 хувь нь НББ, тайлагналтай, 7.1 хувь нь арвилан хэмнэлт, үр ашигтай, 60.2 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 6.3 хувь нь дотоод хяналттай, 1.4 хувь нь худалдан авалттай, 1.2 хувь нь зориулалтын бус зарцуулалттай холбоотой ба 0.4 хувь бусад хэлбэрийн зөрчил байна.

Санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг зохих журмын дагуу хянаж олгодог бөгөөд цаг тухайд нь бүрэн олгоогүй зардал бүртгэгдээгүй байна.

Ерөнхий боловсролын 10 сургууль 2017-2020 онд төсвийн төсөв боловсруулахдаа нийт 65.5 сая төгрөгийг "Орой, эчнээ сургалтаар суурь, бүрэн дунд боловсролын стандарт хэрэгжүүлэх үйлчилгээ"-д зарцуулахаар төлөвлөсөн боловч аймаг, сумын ИТХ-аар сургуулиудын төсвийг батлахдаа хэлэлцээгүй байна.



Дүрслэл 6

Иймд аймаг, сумын ИТХ төсвийг хэлэлцэхдээ шаардлагатай зардлыг заавал хэлэлцэн орон нутгийн төсвөөс баталдаг байхаар "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-д тусгаж өгөх нь зүйтэй.

Аудитад хамрагдсан 2017-2019 онуудад аймгийн хэмжээнд ЕБС-дад ном, сурах бичиг худалдан авах хөрөнгө хуваарилагдаагүй байна.

"Багшийн хөгжлийг дэмжих тухай" хуульд зааснаар 2019 онд аймгийн хэмжээнд багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд нийт 124.2 сая төгрөг хүртэл зарцуулах боломжтой байжээ. Гэтэл гүйцэтгэлээр 27.4 сая төгрөг зарцуулагдсан нь хангалтгүй үзүүлэлт юм. Баянхутаг, Дадал, Норовлин, Цэнхэрмандал, Хэрлэн-1, Хэрлэн-4 ЕБС тодорхой хэмжээний зардлыг багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан ба ихэвчлэн "Багшийн хөгжлийн төв"-ийг тохижуулахад зориулсан байна.

Аймаг, сумын Төрийн сан, аймгийн БСУГ-аас хувьсах зардлын олголтод хяналт тавьсан баримт байхгүй байна.

"Үдийн цай" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жилд дундажаар 653.2 сая төгрөг зарцуулагдсан байна. Баянхутаг сумын ЕБС үдийн цайны зардлыг 2018 онд хэтрүүлэн зарцуулсан нь өвөл, хаврын улиралд олон тооны өрх бусад, аймаг сумаас оторлон ирсэнтэй холбоотой аж. Батноров, Баян-Овоо, Биндэр, Дархан, Дэлгэрхаан, Хэрлэнбаян Улаан, Мөрөн, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Хэрлэн-1, Хан Хэнтий ЦС, Тэмүүжин ЦС болон Насан туршийн боловсролын төвийн "Үдийн цай"-ы гүйцэтгэл 97.4-99.9 хувь байгаа нь санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж олгодогтой холбоотой байна.

Нийт ЕБС-иудад "Сургууль хөгжүүлэх сан" байхгүй байна. ЕБС-иудын ой, тэмдэглэлт үйл явдлаар өгсөн төгсөгчдийн хандив, тусламж, эцэг, эхчүүдийн анги засвар, тохижилтод цуглуулсан мөнгийг бүртгэх, зарцуулалтад нь бүрэн хяналт тавих боломжгүй байна. Иймд "Сургууль хөгжүүлэх сан"-ийн данстай холбоотой эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛТ ХАНГАГДАЖ БАЙГАА Ч ТҮҮНД ХИЙГДЭЖ БҮЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Б.1 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫГ “ЦӨМ” ХӨТӨЛБӨРИЙН ДАГУУ БОЛОВСРУУЛСАН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ОЛГОЖ БҮЙ БОЛОВЧ СУРГАЛТЫН ЧАНАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ БОДИТОЙ БУС БАЙНА.

Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж байна.

Хүүхэд бүрийг хөгжүүлэх дэлхий нийтийн болон Монгол Улсын “Боловсролын тухай” хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үзэл санааг тусган, боловсролыг шинэчлэх хэрэгцээ шаардлага, хөгжлийн чиг хандлагыг баримтлан бага дунд боловсролын сургалтын "Цөм" хөтөлбөрийг боловсруулж 2014-2016 онд улсын хэмжээнд үе шаттай хэрэгжүүлсэн хөтөлбөр нь аймгийн хэмжээнд ерөнхий боловсрол олгох сургуулиудын сургалтын хөтөлбөрт орж хэрэгжсэн байна.

Улмаар БСШУС-ын Сайдын 2019 оны 8 сарын 1-ний өдрийн А/491 дүгээр тушаалаар “Сургалтын төлөвлөгөө”, А/492-р тушаалаар бага, дунд, бүрэн дунд боловсролын сайжруулсан “Сургалтын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталснаар 2019 оноос сургуулиуд сургалтандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн Боловсролын хүрээлэнгийн захирлын 2019 оны 09 сарын 06-ны өдрийн А/35-р тушаалаар хичээл бүрийн “Суралцахуйн удирдамж”-ийг баталж гаргасныг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээний 25 сургуульд "Цөм" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн БСУГ зөвлөн туслах ажлыг жил бүр зохион байгуулжээ. БСШУС-ын Сайдын 2019 оны 8 сарын 1-ний өдрийн А/491 дүгээр тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрт “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг 1-12-р ангид судлахаар нэмж оруулсан ба дунд ахлах ангид энэ хичээлийг нийгмийн ухааны багш заахаар тусгаж оруулсныг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4

Хичээлийн жил	Танин мэдэхүйн чадамж	Хэл-нийгмийн чадамж	Амьдрах ухааны чадамж	Суралцах чадварын хөгжил	Шинжлэх ухааны ойлголт	Судлах сонирхол эрмэлзэл
2016-2017 он	77.5	77.9	76.2	74.8	69.9	76.5
2017-2018 он	80.1	80.7	78.1	75.6	70.4	78.5
2018-2019 он	80.1	81.4	78.4	76.1	72.7	77.2
3 жилийн дундаж	79.2	80.0	77.6	75.5	71.0	77.4

Үүнээс гадна бага, дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт “Багш зохицуулах цаг”-ийг нэмж оруулсан ба сурагчдын сурлагын хоцрогдол арилгах, давтлага өгөх, дугуйлан хичээллүүлэхээс гадна эцэг эхэд “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн агуулга болон ажил мэргэжлийн зөвлөлгөө өгөхөөр нэмж оруулжээ.

Аудитаар сумдад ажиллахад хөдөө орон нутагт сурагчдын тоо цөөн, багш ажиллагсдын норм, норматив, мэргэжлийн багш дутагдалтай, анги танхимын хүрэлцээ хангамж тааруу зэрэг үндэслэлээр зарим хичээлийг мэргэжлийн бус багшаар заалгаж байгаа, багш нарын ур чадвар болон сургалтын орчноос хамаарч сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй эзэмшүүлэхэд үр дүн нь хангалттай биш байна.

Тухайлбал анги танхимын хүрэлцээнээс шалтгаалан хими, физик, биологи, гадаад хэлний зориулалтын танхимгүй, шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг, 1 ээлжээр хичээллэх боломжгүйгээс дугуйлан, секцэд хамрагдах боломж бага байдаг зэрэг нь сургалтын чанарт нөлөөлж байна.

Мөн 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсэн 8 түвшний үнэлгээг эцэг, эхчүүд одоо хүртэл бүрэн ойлгоогүй байна.

Хэнтий аймгийн ерөнхий боловсрол олгож байгаа төрийн өмчийн 25 сургууль, хувийн хэвшлийн 1 нийт 26 сургууль бүгд салбарын яамнаас баталсан албан сурах бичгээс бусад нэмэлт сурах бичгийг ашиглаагүй байна.

Мөн тус аймагт олон улсын сургалттай мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, хувийн сургуулиуд үйл ажиллагаа явуулдаггүй.

Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарт хийгдсэн БҮТ-ийн үнэлгээ бусад үнэлгээнээс хэт их бууралттай байна.

- ЕБ-ын чанарын үнэлгээний судалгааг бодитой, хэвшил хэв шинж харгалзахгүй бүрэн хамруулж хийж байна уу? /Төрийн болон хувийн сургууль, тусгай хэрэгцээт, хилийн чанад дахь, ОУ-ын хөтөлбөртэй сургуулиуд, МСҮТ, насан туршийн боловсролын газар зэргээр түүвэрт бүрэн хамруулсан уу/

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсрол олгож буй 26 сургууль, 1 НТБТөвөөс 22 сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг аудитад хамруулан 2016-2019 оны 3 хичээлийн жилийн дунджаар авч үзвэл бага ангид нийт 572385 цагийн хичээл орохоос 14026 цагийн хичээл өвчтэй, чөлөөтэй, ажил тасалсны улмаас дутагдан 97.4%-ийн гүйцэтгэлтэй, дунд анги 577395 цагийн хичээлээс 14693 цагийн хичээл өвчтэй, чөлөөтэй, тасалсны улмаас дутагдан 97.2%-ийн гүйцэтгэлтэй, ахлах ангид нийт 265825 цагийн

хичээлээс 4837 цагийн хичээл өвчтэй, чөлөөтэй, тасалсны улмаас дутагдан 98.1%-ийн гүйцэтгэлтэй буюу сургалтын төлөвлөгөөний дутагдал жигд түвшинд байна.

Хүснэгт 5


Хичээлийн жил	Өвчтэй	чөлөөтэй	тасалсан	нийт	Нийт хичээлийн цагт эзлэх хувь
2016-2017	5382	5785	210	11377	2,6%
2017-2018	5277	5085	404	10767	2,4%
2018-2019	5138	5799	474	11412	2,4%

Сургалтын төлөвлөгөөний тасралт харьцангуй бага байгаа боловч сурагчдад тухайн багшийн заагаагүй хичээлийг нөхөн заах эсвэл багш орлон заах хэлбэрээр бүрэн нөхөж сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан байна.

Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцоход Бор-Өндөр, Галшар, Дархан сумын ЕБС-ууд, Бор-Өндөр сумын “Их Ирээдүй” сургууль тус тус аудитад холбогдох мэдээллээ ирүүлээгүй.

Аудитад хамрагдсан сумд болон аймгийн Насан туршийн боловсролын төвөөс авч нэгтгэсэн мэдээллээр 2016-2017 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр 523 хүүхэд сургахаар төлөвлөснөөс 144 хүүхдийг сургалтанд хамруулснаас 14 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 2017-2018 онд 517 хүүхэд сургалтанд хамруулахаар төлөвлөснөөс 130 хүүхэд хамрагдсаны 15 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 2018-2019 онд 156 хүүхэд хамруулахаар төлөвлөснөөс 152 хүүхэд хамруулсны 12 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тус тус хамруулжээ. Мөн насан туршийн боловсрол олгох сургалтын хүрээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 2016-2017 онд 4228 хүн, 2017-2018 онд 1763 хүн, 2018-2019 онд 17367 хүнийг тус тус хамруулжээ.

Дүрслэл 7



Тус аймгийн хэмжээний бүх ерөнхий боловсролын сургуулиуд сургалтын чанарт хийх үнэлгээг 2016-2017, 2018-2018 оны хичээлийн жилд хийж хэвшсэн боловч 2018 оноос 8 түвшний үнэлгээний системд шилжсэнээр Батноров сум, Бэрх тосгоны сургуулиуд аудитад хамрагдсан 2018-2019 оны хичээлийн жилээс сургалтын чанарыг 100 хувиар тооцож үнэлээгүй, бусад сургуулиудад хийгдсэн байна.

Энэ нь тус үнэлгээний журмын талаар сургуулиуд нэгдсэн ойлголттойгоор ижил түвшинд хэрэгжүүлэхгүй байгаа нь аймгийн БСУГ нь ЕБС-дад сургалт, зөвлөгөөн, зөвлөн туслах ажил хийх шаардлагатай, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг буцаан дүгнэдэг болох хэрэгтэйг харуулж байна.

Аймгийн хэмжээний ЕБС-дын өөрсдийнх нь хийсэн чанарын үнэлгээг дунджаар гарган аймгийн БСУГ болон БҮТ-тэй харьцуулбал бага ангийн чанарын үнэлгээ аймгийн БСУГ-ын чанарын үнэлгээнээс 6.4 оноогоор, БҮТ-ийн чанарын үнэлгээнээс 40.2 оноогоор илүү, дунд ангийн чанарын үнэлгээ аймгийн БСУГ-ын чанарын үнэлгээнээс 30.5 оноогоор, БҮТ-ийн чанарын үнэлгээнээс 37.1 оноогоор илүү, ахлах ангийн чанарын үнэлгээ аймгийн БСУГ-ын чанарын үнэлгээнээс 33.2 оноогоор, БҮТ-ийн чанарын үнэлгээнээс 47.6 оноогоор дээгүүр үнэлсэн нь үнэлгээг бодитой бус хийж байгаатай холбоотой.

Аудитад Галшар, Бор-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулиуд сургалтын чанарт үнэлгээ хийсэн материалыг хамруулаагүй тул бусад 24 ЕБС-ийн дунджаар гаргасан үнэлгээ гэж үзвэл зохино.

Аудитаар сумдын ЕБС-дад ажиллахад анги дүүргэлт 35-аас дээш ангид 8 түвшний үр дүнгийн үнэлгээг 8-17 судлагдахуунаар сурагчдаа зөв оношилж, чиглүүлэх арга зүйд улам сайн сургахад багш, сурагчдын цагийн ачаалал их, анги дэвших болон улсын шалгалтын үед эцэг эхийн оролцоог сайжруулах, эцэг эхчүүдэд үнэлгээний шинэ журмын талаар мэдлэг ойлголтыг таниулах шаардлагатай байгаа талаар саналаа хэллээ.

Мөн Боловсролын үнэлгээний төвөөс хийж буй шалгалт нь бүх сургуулийг хамардаггүй, бүх хичээлийг хамруулдаггүй учир үнэлгээний хувь буурах эрсдэл өндөр байна гэж үзэж байна.

Жишээ нь Хэнтий аймгийн 25 ЕБС-д сургуулийн болон аймгийн БСУГ-аас чанарын үнэлгээ хийгдсэн бол БҮТ-өөс Бэрх, Хэрлэн-1, Хэрлэн-4-р сургуульд, 2017-2018 оны хичээлийн жилд Өмнөдэлгэр, Хэрлэн-1, Тэмүүжин ЦС-д л чанарын үнэлгээ хийгдсэн байна.

Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын чанарт олон улсын магадлан итгэмжлэл оруулахтай холбоотойгоор 2018-2019 оны хичээлийн жилд аймгийн хэмжээний төрийн өмчит 23 сургуулийн 9-р ангид БҮТ-ээс нэгдсэн журмаар үнэлгээ хийгдсэн бол 2019-2020 оны хичээлийн жилд аймгийн БСУГ-аас хүсэлт тавин БҮТ-тэй хамтран бүх сургуулийн бага, дунд ахлах ангиудыг чанарын үнэлгээнд хамруулсан нь аймгийн хэмжээний сурагчдын сурлагын чанарыг бодитой тогтоох, үнэлгээний түвшинг ахиулах томоохон ажлыг санаачлан зохион байгуулсан байна.

Үүний дүнд БҮТ-өөс урьд нь үзүүлж байсан сурлагын амжилт, чанарын үзүүлэлт тодорхой хувиар дээшилсэн нь сурагчдын үнэлгээг бодитой гаргахад түлхэц болсон ажил болжээ.

Дүрслэл 8



Б.2 БҮХ НИЙТИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ ХЭРЭГЖИЖ БУЙ БОЛОВЧ ҮР ДҮНГ ЭРГЭН ХЯНАХ АЖИЛ ДУТУУ ХИЙГДЭЖ БАЙНА.

Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналт хэрэгжиж байгаа боловч үр дүнг тооцож, сайжруулах ажил хийгдэх нь дутмаг байна.

Боловсролын үнэлгээний төвөөс сургалтын чанарт хийсэн үнэлгээгээр ЕБС, аймгийн БСУГ-ын үнэлгээтэй харьцуулбал бага ангийг ЕБС-ын үнэлгээнээс 40.2 оноогоор доогуур, аймгийн БСУГ-ын үнэлгээнээс 33.8 оноогоор доогуур, дунд ангийг ЕБС-ын үнэлгээнээс 37.1 оноогоор доогуур, аймгийн БСУГ-ын үнэлгээнээс 6.5 оноогоор доогуур, ахлах ангийг ЕБС-ын үнэлгээнээс 47.6 оноогоор доогуур, аймгийн БСУГ-ын онооноос 14.4 оноогоор доогуур тус тус үнэлсэн байна.

Гэсэн хэдий ч БҮТ нь сурагчдын сурлагын чанарт хийх үнэлгээг хийхдээ сургууль болон хичээлүүдийг түүвэрлэн авч хийдэг нь үнэлгээний дүн хэлбэлзэх, бодитой, бүрэн хамарсан байх шаардлагыг хангаагүй тул сургуулиудын үнэлгээтэй шууд харьцуулах дүгнэх нь учир дутагдалтай юм.

Үнэлгээний төвөөс сургалтын чанарыг үнэлэхдээ сургалтын хөтөлбөрт тохирсон үнэлгээгээр үнэлэхгүй байгаагаас сургалтын чанарын үнэлгээ бодитой бус гарахад нөлөөлж байж болох тул цаашид БҮТ-өөс хийх чанарыг үнэлгээнд сургуулиудыг бүрэн хамруулах, хичээлийг нэг төрлөөр дагнан шалгах нь үнэлгээг бодитой тогтооход нөлөөлөх хүчин зүйл болох юм.

Аймгийн бүх сургуулиудад аудитад хамрагдсан 2016-2019 оны хичээлийн жилүүдэд БСШУЯамны Ерөнхий боловсролын бодлогын газар, Боловсролын хүрээлэнгээс хяналт шалгалт, зөвлөн туслах ажил газар дээр очиж хийгдээгүй байна.

Ерөнхий боловсрол олгохдоо суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/309 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам"-аар дүгнэж байснаа 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн БСШУС-ын сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/425 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын дагуу 8 түвшнийг 5 шалгуураар үнэлж байна.

Аймгийн БСУГ-аас аудитад хамрагдсан 3 жилээр бүх сургуулиудыг хамруулан сургалтын чанарт үнэлгээ хийсэн байна. Гэсэн хэдий ч аудитад хамрагдсан 3 жилээр үнэлгээг дунджаар авч үзвэл бага ангийн үнэлгээг ЕБС-ийн үнэлгээнээс 6.4 оноогоор бага, дунд ангийг 30.5 оноогоор бага, ахлах ангийг 33.2 оноогоор бага үнэлсэн бол БҮТ-ийн үнэлгээнээс бага ангийг 33.8 оноогоор дээгүүр, дунд ангийг 6.5 оноогоор дээгүүр, ахлах ангийг 14.4 оноогоор дээгүүр үнэлсэн байна.

Дүрслэл 9



Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй суралцагчдаас авах шалгалтыг бүх хичээлээр үнэлж байвал сурагцагчдын сургалтын чанар илүү бодит үнэлгээ гарна. Сумдын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын үйл ажиллагааг

шалгахад 2016-2017 оны хичээлийн жилд 9 сургуулийн дотоод хяналтын нэгж үйл ажиллагаа явуулж нийтдээ 92 удаагийн хяналт зохион байгуулж 171 зөрчилд 28 зөвлөмж, албан шаардлага, 2017-2018 оны хичээлийн жилд 14 сургууль 165 удаагийн хяналт хийж 387 зөрчилд 142 зөвлөмж, албан шаардлага, 2018-2019 оны хичээлийн жилд 14 ЕБС 179 удаагийн хяналт хийж 363 зөрчилд 145 зөвлөмж, албан шаардлага өгч, хэрэгжилтийг шалган хичээлийн жилийн эцэст дотоод хяналтын үйл ажиллагааг тайлагнасан байна.

Аудитад хамрагдсан 3 жилд хийгдсэн дотоод хяналтын талаар Хэрлэн-1 ЕБС, Хан-Хэнтий ЦС, Хэрлэн-4, Жаргалтхаан сумын ЕБС-ууд архивын нэгж үүсгэн хадгалаагүй, Батноров сумын ЕБС, Баян-Адарга сумын ЕБС, Бор-Өндөр сумын ЕБС, Дадал сумын ЕБС, Норовлин сумын ЕБС, Цэнхэрмандал сумын ЕБС, Галшар сумын ЕБС, Баянхутаг сумн ЕБС, Мөрөн сумын ЕБС-ын дотоод хяналтын зарим хичээлийн жилийн баримт байхгүй бол, Баян-Овоо сумын ЕБС, Дэлгэрхаан сумын ЕБС, Өмнөдэлгэр сумын ЕБС, Гурванбаян тосгоны ЕБС, ХБУлаан тосгоны ЕБС-дад очиж ажиллаагүйгээс дотоод хяналтын баримт аудитад хамрагдаагүй.

Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцох чиглэлээр БСШУСЯ-ны сайдын 2003 оны А/321-р тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт батлах тухай” журмыг 2003-2019 оны хооронд хэрэгжүүлж байсан бол 2019 оноос БСШУСЯ-ны сайдын “Цэцэрлэг сургуулийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх журам” А/803 дугаар тушаал шинээр батлагдсаныг аймгийн хэмжээнд мөрдөж байна.

Аудитад хамрагдсан 2017-2019 оны хичээлийн жилд аймгийн БСУГ-аас 25 сургуулийн үйл ажиллагаанд жилд 1-3 удаа зөвлөн туслах үйл ажиллагааг хийхдээ сургуулиудыг газар зүйн байршлаар нь 4 бүсэд хуваан, жил бүр багш нарын баяр угтсан арга хэмжээг тухайн жилийн бодлого чиглэлийн хүрээнд уялдуулж зохион байгуулжээ.

Энэ үеэр сургуулиуд хүндрэлтэй асуудлаа хэлэлцэж, сайн туршлагыг түгээж, аливаа асуудлын шийдлийн гаргалгааг бүсийн хэмжээнд мөн БСУГ-ын хэмжээнд тусгах ажлыг зохион байгуулсан байна.

Харин сумдад ажиллах үед аймгийн БСУГ-аас хийсэн хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын талаар архивын баримт үүсгээгүй байгаа нь тус ажлын үр дүнг тооцох, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг тайлагнах ажил хийсэн талаарх баримт байхгүй байна.

Аудитаар сумдад ажиллахад БҮТ-өөс нэг хичээлийн жилд ганцхан удаагийн чанарын үнэлгээ хийж тухайн сургуулийн бүтэн жилийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх нь учир дутагдалтай, сургалтад чиглэсэн хөндлөнгийн үнэлгээ хүүхдийн ялгаатай байдалд тохирсон агуулгаар ирдэггүй, ахисан түвшний хүүхдүүдэд нийцэхээр ирдгээс багшийн ажил бодитоор үнэлэгддэггүй, үнэлгээний систем өөрчлөгдсөн талаархи иргэдийн мэдээлэл хангалтгүй, БСШУ-ын сайдын А/321 тоот тушаал "Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагааг үнэлэх журам-ын дагуу сургуулийн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэн боловсролын үнэлгээний үр дүнг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулж хэвшээд байсан боловч 2019 оны 12 дугаар сарын 17-нд БСШУС-ын сайдын А/803-р тушаалаар журам шинэчлэгдэн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх арга зүй, шалгуур үзүүлэлт өөрчлөгдсөнөөр үнэлгээг хийж хэвших хугацаа алдаж байна зэрэг саналууд гарч байна.

Хэнтий аймгийн хэмжээнд багш бэлтгэх их, дээд сургууль үйл ажиллагаагаа явуулдаггүй бөгөөд ерөнхий боловсрол олгож буй сургуулиудын багш нарын мэргэжлийг нэгтгэн үзэхэд дунджаар нийт багш нарын 75 хувь нь багш нь мэргэжлийн багш нар бол бусад нь багш бус мэргэжлийн эрхийн шалгалтанд ороогүй эхний жилдээ багшилж байгаа ажилтнууд бөгөөд давтан, эчнээ, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байгаа болно.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн 25, хувийн хэвшлийн 1, нийт 26 сургуулиуд бүгд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөө гаргуулсан хүчин төгөлдөр эрхтэй байна. Үүнээс 25 сургуулийн тусгай зөвшөөрлийг Хэнтий аймгийн Засаг дарга олгосон бол Хэрлэн сумын лаборатори 1 дүгээр сургуулийн тусгай зөвшөөрлийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгосон байна.

Гэвч өөр өөр нэршилтэй байсан сургуулиудын нэршлийг аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/24 тоот Захирамжаар оноосон нэрийг өөрчлөн нэг нэршилд оруулсан байна.

Ингэхдээ 2012 онд тусгай зөвшөөрөл нь гарсан, хүчин төгөлдөр эрх нь дуусгавар болоогүй байхад Хэрлэн сумын "Тэмүүжин" ЦС, "Хан Хэнтий" ЦС, Хэрлэн-4 дүгээр сургууль, "Бор-Өндөр" ЦС, Бэрх тосгоны ЕБС, Биндэр сумын ЕБС, Өмнөдэлгэр сумын ЕБС, Өлзийт тосгоны ЕБС, Батноров сумын ЕБС зэрэг 9 сургуульд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг давхардуулан олгосноор тус сургуулиуд хоёр тусгай зөвшөөрөлтэй болсон байна.

Хүснэгт 6

ЕБС-дын нэр	2012 онд ТЗ олгосон бүртгэлийн дугаар	Дуусах хугацаа	2019 онд олгосон ТЗ дугаар	Дуусах хугацаа
"Тэмүүжин" ЦС	12 18 2 1025	2023-09-19	21	2023-09-19
"Хан-Хэнтий" ЦС	12 18 2 1024	2023-09-19	20	2023-09-19

Хэрлэн сумын 4-р сургууль	12 18 2 1023	2023-09-19	19	2023-09-19
“Бор-Өндөр” ЦС	12 18 2 10	2023-09-19	18	2023-09-19
Бэрх тосгоны ЕБС	12 18 2 10	2023-09-19	24	2023-09-19
Биндэр сумын ЕБС	12 18 2 10	2023-09-19	23	2023-09-19
Өмнөдэлгэр сумын ЕБС	12 18 2 10	2023-09-19	25	2023-09-19
Батноров сумын ЕБС	12 18 2 1012	2023-09-19	17	2023-09-19
Өлзийт тосгоны ЕБС	12 18 2 10	2023-09-19	22	2023-09-19

Б.2.2 Ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг аймгийн МХГ хэрэгжүүлж бусад байгууллагаас хийгдсэн хяналт байхгүй байна.

Аудитаар сумдын ерөнхий боловсролын сургуульд ажиллахдаа тухайн сургуульд хийгдсэн аймгийн МХГ-ын шалгалтын байдлыг газар дээр нь үзэхэд 2016-2017 оны хичээлийн жилд 5 сургуульд ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт хийхэд дунджаар 22%-ийн буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн бол сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцаа, дотуур байрны эрүүл ахуйн чиглэлээр нийт 22 хяналт шалгалтыг давхардсан тоогоор 9 сургуульд хийж 31-37%-ийн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

2017-2018 оны хичээлийн жилд 1 сургуульд ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт хийхэд 31%-ийн буюу дунд эрсдэлтэй, сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцаа, дотуур байрны эрүүл ахуйн чиглэлээр нийт 16 хяналт шалгалтыг давхардсан тоогоор 5 сургуульд хийж 29-84%-ийн дунд ба их эрсдэлтэй үнэлэгджээ.

2018-2019 оны хичээлийн жилд 2 сургуульд ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаанд хяналт хийхэд дунджаар 28%-ийн буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бол сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн харилцаа, дотуур байрны эрүүл ахуйн чиглэлээр нийт 22 хяналт шалгалтыг давхардсан тоогоор 6 сургуульд хийж 18-75,5%-ийн дунд ба их эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

Харин аймгийн МХГ-аас аудитын хугацаанд ерөнхий боловсролын сургуулиудад хяналт шалгалт хийсэн талаархи дэлгэрэнгүй материалыг ирүүлсэнгүй.

Хэнтий аймгийн сумд, тосгоны ЕБС-даас Мөрөн сумын сургуульд сургуулийн зөвлөл байгуулсан боловч үйл ажиллагаа явуулсан талаархи тайланг аудитад хамруулсангүй. Бусад төрийн өмчийн 24, хувийн хэвшлийн 1 сургуульд “сургуулийн зөвлөл”-ийг эрх бүхий байгууллагын байгуулсан шийдвэр байхгүй, үйл ажиллагаа явуулсан ажлын төлөвлөгөө, тайланг аудитад хамруулсангүй.

Монгол улсын "Боловсролын тухай" хуулийн 37.2³-т заасан тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий субъект болох аймгийн Засаг даргаас аймгийн нийт ерөнхий боловсролын сургуульд тусгай зөвшөөрлийн талаархи хяналтыг тавих үүргээ 2016-2019 оны хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Ийнхүү хэрэгжүүлээгүйгээс "Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл"-ийн хавсралт сургалт эрхлэх нөхцөл шаардлагад дурьдагдсан сургалтад баримтлах хяналтын үзүүлэлтүүдийг өөрчилдөггүй нь "тусгай зөвшөөрөлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл"-ийг хийдэггүйтэй холбоотой.

Аудитад хамрагдсан 2016-2017 оны хичээлийн жилд тухайн сумын ЗДТГ-аас сургуулиудын ерөнхий боловсрол эзэмшиж байгаа байдалд хяналт, шалгалт хийсэн баримт байхгүй байгаа бол 2017-2018 онд Баян-Адарга, Мөрөн сумын ЗДТГ-аас тус бүр 1 удаа, 2018-2019 оны хичээлийн жилд Жаргалтхаан сумын ЗДТГ-аас 1 удаа хяналт шалгалт хийжээ. Бусад сумын ЗДТГ-аас энэ хугацаанд сургуулийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн ажлын баримт аудитад хамрагдсангүй.

³ 37.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

Холбогдох байгууллагын санал:


**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗАР**
23117 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Баянмөнх баг
Утас: 70-56-36-40
Э-шуудан: khentiibsg@gmail.com
Вэйб сайт: www.khentiitpd.mn

долоо 11.02 № 234
танай _____ -ны № _____ -Т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Бидний ажилд оршиж буй алдаа оноо, зөрчил дутагдлыг тодорхойлон гаргаж өгсөнд талархлаа.
Бид цаашид ажилдаа мөрдөн ажиллах болно.

ДАРГА  С.МӨНХЦЭЦЭГ

D:/alban bichig A4, A5, tushaal/

Саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас тайлангийн төсөлд санал ирүүлээгүй болно.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Бүх нийтийн боловсрол олгоход мөрдөж байгаа бодлого, хөтөлбөр богино хугацаанд өөрчлөгдөж, шинэчлэгдэж байна.
- Бага, суурь боловсрол эзэмшүүлэхэд сум, багууд харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах, суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх сум, багийн Засаг дарга нар бүрэн эрхээ хангалттай хэрэгжүүлж чадахгүй байна.
- ЕБС-дад байгалийн шинжлэлийн кабинетууд, мэргэжлийн чиг баримжаа олгох болон материал боловсруулах өрөө, тэдгээрийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж хангалттай биш байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн мэргэшсэн түвшин нь албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангахгүй байна.
- ЕБС-иуд дийлэнх нь ил ариун цэврийн байгууламж ашиглаж байна.
- Байгалийн шинжлэл, гадаад хэл, мэргэжлийн чиг баримжаа олох болон материал боловсруулах технологийн багшийн хангамж дутагдалтай байна
- Төсвийг бодитой төлөвлөж чадаагүйгээс оны эцэст дахин хуваарилалт хийж, төсвийг тодотгож байна.
- “Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал”-ын бүрэлдэхүүнд багтдаг хангамж бараа материал, эд хогшил, урсгал засвар, бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан төсөв хүрэлцээгүй байна.
- Боловсролын байгууллагуудад хэрэгжсэн хөтөлбөр болон дотоод хяналтын ажлын баримтыг архивын нэгж үүсгэн хадгалаагүй байна.
- Суралцагчдын сургалтын чанарт хийсэн 3 шатны үнэлгээ зөрүүтэй байгаа нь үнэлгээ бодитой хийгдсэн гэх үндэслэл бага байна.
- Ерөнхий боловсролын байгууллагуудад хийгдэж буй хөндлөнгийн хяналт шалгалтын баримт хомс, өгсөн зөвлөмж түүний хэрэгжилтийг тооцох талаар хийгдсэн ажил тодорхой бус байна.
- Зарим ерөнхий боловсролын сургуулиуд дотоод хяналтын нэгж байгуулаагүй буюу энэ талаар хийгдсэн ажил тодорхойгүй байна.
- Нийт багш нарын 93% нь багшлах эрхийн үнэмлэхтэй байгаа нь сургалт эрхлэх нөхцөл шаардлагыг хангаж байна.
- Ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагад тавих хяналт хийгдэхгүй байгаагаас зарим сургуулиудад “тусгай зөвшөөрөл”-ийг давхардуулан олгосон байна.
- Ерөнхий боловсролын сургуулиудад “Сургуулийн зөвлөл”-ийг байгуулаагүй, хуульд заасан чиг үүргүүд хэрэгжээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга Ц.Идэрбат-д

- Бага, суурь боловсрол эзэмшүүлэхэд сум, багууд харьяа айл өрхийн 06-14 насны хүүхдийг бүрэн хамруулах, суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэлтийг сум, багийн Засаг дарга нарын ажлыг дүгнэх үзүүлэлт болгон оруулж, дүгнэдэг байх,
- Давхардуулан олгосон “тусгай зөвшөөрөл”-ийн давхардлыг арилгах, түүнд хийгдэх хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж байх,
- ЕБС-иудын ил ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа байдлыг зогсоож, боловсон ариун цэврийн байгууламжаар хангахад төсөв, хөрөнгийн дэмжлэг үзүүлэх,

Аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын дарга С.Мөнхцэцэг-т

- ЕБС-дын лаборант бүхий байгалийн шинжлэлийн кабинетууд, мэргэжлийн чиг баримжаа олгох болон материал боловсруулах өрөөнүүдэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах ажлын төлөвлөгөө боловсруулан гаргаж богино хугацаанд хэрэгжүүлэх,
- Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн мэргэшлийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, сургалтанд хамруулах.
- Байгалийн шинжлэлийн хичээлийг заах багшийн хөрвөх чадварыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ойрын хугацаанд хэрэгжүүлэн, үр дүнг тооцох,
- Гадаад хэл, мэргэжлийн чиг баримжаа олгох болон материал боловсруулах технологийн хичээлүүдийг группээр хичээллүүлэх боломжийг судлан, багшийн хангалтыг сайжруулах,
- Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар тооцож байгаа “Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардал”-н бүрэлдэхүүний хуваарилах хувь хэмжээг бодит үр дүнд тулгуурлан жил бүр шинэчлэн тогтоож байх,
- Ерөнхий боловсролын сургуулиудад дотоод хяналтын нэгжийг байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулах ажлыг зохион байгуулах,
- Суралцагчдын сурлагын чанарын үнэлгээний зөрүүг арилгах ажлыг зохион байгуулах,
- Сургуулиудад хөтөлбөр, төлөвлөгөө болон дотоод, хөндлөнгийн хяналтын ажлын талаарх архивын нэгж бүрдүүлэх талаар удирдлага зохион байгуулалтаар хангах,
- Ерөнхий боловсролын байгууллагуудад “Сургуулийн зөвлөл”-ийг байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулах,


Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ-д

- Төрийн аудитын байгууллагын төлөвлөгөөний дагуу хийгдэж буй гүйцэтгэлийн аудитад шаардлагатай мэдээллийг “Төрийн аудитын” тухай хуулийн 16.1.4-т заасан хугацаанд саадгүй гаргаж ирүүлж байх,

Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал:

- Аймаг, сумын ИТХ ирэх оны төсөв хэлэлцэхдээ албан бус сургалтад шаардлагатай зардлыг заавал хэлэлцэн ЕБС-ийн төсөвт тусган баталдаг байхаар **"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"**-д тусгаж өгөх,
- Сургуулийн зөвлөл байгуулагддаггүй, байгуулагдсан нь хуульд заасан чиг, үүргээ хэрэгжүүлдэггүй байх тул зөвлөлийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийг **"Боловсролын тухай"** хуулийн аймаг, сумын ИТХ-ын бүрэн эрхэд нэмж өгөх,
- **"Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал"**-д санхүүжих хүүхдийн тоог тооцоолох аргачлал тодорхой бус байгаа тул **"ТОДОРХОЙ"** болгох зөвлөмжийг БСШУ-ы сайдад хүргүүлэх,
- **"Боловсролын тухай"** хуулийн 40.3-д заасан **"Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно"** гэсэн заалт хэрэгжихгүй байгааг уламжлах,
- **"Боловсролын тухай"** хуулийн 39.11-т **"Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална"** гэж заасны дагуу БСШУ-ны сайд, Сангийн сайдын 2008 оны 56/64 дүгээр хамтарсан тушаалаар **"Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм"**-ийг баталсан боловч **"Төсвийн тухай"** хуулийн 18 дугаар зүйлд заасан тусгай санд хамаарахгүй тул дээрхи сан байгуулах боломжгүй байгаа эрх зүйн зөрчлийг арилгах саналаа хүргүүлэх,

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:




**ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 10 дугаар сарын 20 Дугаар 9/сз Чингис хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай Г

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан "Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн удирдамжаар хийгдэж буй "Төрөөс бүх нийтийн боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Боловсрол соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭРДЭНЭБААТАР

023010099